

**2026 онд Монгол Улсад шүүх байгуулагдсаны 125 жил,
Улсын дээд шүүхийн 100 жилийн түүхт ой тохиож байна**

“Шүүх бол бидний гэр орд юм”

Өнгөрснөөс эдүгээ үе үүссэн. Эх түүхээ мэдэхгүй бол ойд төөрсөн мэт. Ирсэн замаа эргэж хараагүй хүн, буцахдаа орон гэрээ олохгүй гэдэг. Үүн лугаа адил Монголын шүүх, шүүхийн системийн хөгжлийн түүхэн замнал, өнгөрсөн хугацаанд бий болсон сургамжийг эх үндсээс нь танин мэдэж, чанд харгалзан үзэхгүйгээр шүүхийн хөгжлийн чиг хандлага, ирээдүйгээ зөв тодорхойлох боломжгүй билээ.



“Шүүх, шүүгчгүйгээр аливаа төрт улсууд оршин байгаагүй” гэж үздэг. Монголчуудын төрт ёс, хууль цаазын арвин баялаг түүхэн уламжлалд шүүх, шүүгчийн түүхэн хөгжил онцгой байр суурь эзэлдэг.

Судлаачид Монголын хууль цааз, төрт ёсны түүхэн хөгжлийг авч үзэхдээ Хүннүгийн эсхүл Хамаг Монголын үеэс эсхүл Монгол гэх Улсыг дэлхийн түүхэнд алдаршуулсан, Эзэнт гүрний үеийн бичмэл гол хууль болох “Их засаг (Яса)” хууль үйлчилж байсан 1206 оноос гэх зэргээр ялгаатай байр суурьтай байдаг.

1755 он гэхэд Монголын тусгаар тогтнолын сүүлчийн гал голомт манжийн эрхшээлд бүрэн орж, нийт Монгол Манжид эзлэгдэж, тэдний ноёрхолд 220 гаруй жил дарлагдсан. Хэдий Манжид 2 зуун дамнан дарлагдсан боловч :

Цусаар нь дэлхий эргэлдэн урсдаг

Цуут, Суут Чингисийн Монгол ялсан, хөгжсөн, мандсан.

Монголын эрэлхэг, эх оронч хөвгүүд “Улс үндэснийхээ эрх чөлөө, тусгаар оршихуй”-н төлөө халуун цус, бүлээн амиа үл хайрлан тэмцсэн 1911 оны Үндэсний эрх чөлөөний хувьсгалаар Манж Чин улсын 220 гаруй жилийн ноёрхлыг түлхэн унагааж, Чингисийн Монголчууд өөрийн төрт улсаа дахин сэргээснийг дэлхийн улсуудад сонордуулан, үүрд мөнх орших суурь нөхцөлийг бүрдүүлэв.

Энэ бүх үйл явдал нь тусгаар тогтнолын төлөө тэмцэгчид өөрийн ба бусад улс орны нөхцөл байдал, үүлэн чөлөө мэт ховор боломжийг зөв мэдэрч, гэгээн оюуныг шилээн тунгааж, олон талт оновчтой бодлого явуулсны үр дүн байсныг түүхэн сурвалжууд гэрчилдэг.




Тийнхүү 1911 оны 12 дугаар сарын 29-нд Богд Жавзандамба хутагтын VIII дүр Агваанлуvsанчойжиннямданзанваанчигбалсамбууг “Шарын шашныг мандуулагч, олныг жаргуулагч, олноо өргөгдсөн Монгол Улсын эзэн, шашин төрийг хослон баригч, наран гэрэлт түмэн наст Богд хаан” хэмээн өргөмжлөн, “Монгол Улс” байгуулсныг албан ёсоор тунхаглав.

1911 онд Богд хаан өргөмжлөгдмөгц буулгасан зарлигаар 5 яам байгуулсны нэг нь жүн Ван М.Намсрайн тэргүүлсэн Шүүхийн хэргийг бүгд захиран шийтгэгч яам, тус яам нь цааз хуулийг барьж, шүүн таслах эрх эдэлж, захирч шийтгэнэ. Тус яам нь дотроо хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаа явуулж шүүх, ял оноож шүүн таслах, ариутгах хэлтсүүдтэй байв.

Богд хаант төр ингэж тогтов. “Бусдын төр миний төр биш, миний төр бусдын төр биш” болов.

Дээрх түүхэн баримтат үйл явдлыг үндэс болгон Монголын Эзэнт гүрний тусгаар тогтнол алдагдан 220 жилээр тасарсан хугацааг Монголын түүхэн тэмдэглэлт үйл явдлын цаг хугацаанд хамааруулах боломжгүй учир Монгол Улсад Шүүх байгуулагдсан цаг хугацааг 1911 он буюу Улс үндэснийхээ бусдад алдагдсан эрх чөлөө, тусгаар тогтнолоо эгүүлэн олж авсан, “ШҮҮХ” яам байгуулсан тухайн цаг үеэс тооцохоор албан ёсоор шийдвэрлэсэн байдаг.

Гэхдээ энэ нь 1911 оноос өмнөх Монголын төрт ёс, хууль цаазын арвин баялаг түүхийг үгүйсгэх, судалж, танин мэдэхгүйгээр орхигдуулж байгаа хэрэгт огт биш гэдгийг бид сайн мэдэх билээ.



Их Монгол Улс дэлхийн эзэнт гүрэн байсан. Шударга ёс, хуулийн засаглал нь дэлхийн эзэнт гүрнийг цогцлооход үндсэн арга, механизм болж байсныг түүхэн сурвалж, судлаач, эрдэмтдийн судалгаа гэрчлэн өгүүлдэг.

Шүүгчийг төрийн тэргүүн (хаан)-ээс томилж байсан хууль зүйн түүхэн уламжлал бий.

“Улсын дээд заргач заргыг шийтгэж, түүнийгээ хөх дэвтэрт бичиж дэвтэрлэгтүн. Надтай зөвлөж, Шихихутуг (улсын дээд заргач)-ийн шийтгээд цагаан дээр хөх бичиг бичиж, дэвтэрлэснийг үргийн урагт хүртэл хэн ч бүү өөрчилтүгэй” хэмээх Чингис хааны “Их засаг” хуулийн зорилго, зарлигууд зэрэг түүхэн эх сурвалжтай олон баримтууд энд хамаардаг.

Чингис хаан “Гүр улсын хулгайг гэсгээж, худлыг мохоож, зэмтнийг гэсгээ. Алдалтан буруутныг алдуул”, “хэрүүл, хулгай, худал үйлстнийг засан заргалтугай” хэмээн улсын заргач буюу шүүгчийг томилдог байж. Мөн Монгол Улсын шүүгчид хууль, шударга ёсны өмнө хамгаас онцгой бүрэн эрх, өндөр үүрэг, хариуцлага хүлээдэг болохыг Чингис хааны буулгасан “Мөнх тэнгэрийн ивээлээр улс гүрнийг тохинуулж байхад чи үзэх нүд, сонсох чих болж яв. Чиний тушаасан үгийг хэн ч өөрчилж үл болно. Бүх улсын доторх хулгайг цээрлүүлж, худлыг мохоож, үхүүлэх ёстойг үхүүлж, яллах ёстойг яллаж бай” гэх лүндэн (зарлиг) бидэнд цаг ямагт сануулах бөлгөө. Энэ бол Улсын шүүгч бүр үеийн үед дээдлэн шүтэж, чандлан сахих амьд гэрээслэл болдог.

Энэ мэтээр Монголын шүүх эрх мэдэлд холбогдох өв их соёлын түүхэн уламжлал, бахархах түүх, сургамжаас бидэнд судалж танин мэдэх зүйлс их бий.

Мөн хэлмэгдүүлэлт бусад бараан түүхүүд шүүхийг тойроогүй ажээ. Шүүхийг гүйцэтгэх эрх мэдэл нь хянахаас гадна шүүхээс гадуур тусгай байгууллага байгуулж шүүхтэй зэрэгцэн шүүх эрх мэдлийг хэрэгжүүлж, шүүх бие даасан, шүүгч хараат бус байх явдал улс төр, зохион байгуулалт, эрх зүйн хувьд ямар ч хамгаалалт, баталгаа байгаагүй, бүхэлдээ нам, засгийн хяналтад байв.

Тийнхүү Монголын шүүхийн түүхэн уламжлал, шинэчлэл, хөгжил бол зөвхөн шулуун дардан замаар замнаагүй байх бөгөөд энэ нь Улс орны хөгжлийн түвшин, эдийн засгийн чадавч зэргээс ялангуяа тухайн үеийн улс төрийн байгууламж буюу дэглэмээс үлэмж хамааралтай байжээ.

Гэхдээ шүүх хэмээх байгууллага бие даах шинжийг олох анхны алхам нь “Бүгд найрамдах Монгол Ард Улсын аливаа шүүн таслах газруудыг байгуулах тухай дүрэм”-ийг баталсан 1926 оны 4 дүгээр сарын 16-ны өдөр гэж үздэг.

Манай үе үеийн шүүх, шүүхийн хамт олон “олон талт бэрхшээл, сорилт, намын ба засгийн хараа хяналт”-ыг зориг тэвчээр, итгэл зүтгэлтэйгээр даван туулж, шинэ цаг үетэй золгожээ.

Хамгийн чухал нь Монголын шүүхийн түүхэн уламжлал, хөгжил, шинэчлэл бол Монголчуудын тусгаар тогтнол, эрх чөлөө, шударга ёс, засаг төрийг хуулийн хязгаарлалтад оруулахын төлөөх олон жилийн тэмцлийн түүхтэй салшгүй холбоотой болохыг түүхэн баримт, эх сурвалжууд өгүүлдэг.

Орчин цагийн хүн төрөлхтний нийтлэг хандлагад нийцүүлэн ардчилал, эрх зүйт төр оршихуйн үндэс нь шүүх эрх мэдэл болохыг шинэ Үндсэн хуулиар баталгаажуулж, шүүх эрх мэдлийн салбарт цогц өөрчлөлт, шинэчлэлийг алхам алхмаар хийсний үр дүнд шүүхийн бие даасан байдал, шүүгчийн хараат бус байдал, боловсон хүчин, хөрөнгө санхүү, техник хэрэгсэл, ажиллах орчин, ахуй нөхцөл бүхий л талаар зохих ёсоор хангагдаж, эдүгээгийн хөгжил, дэвшлийн шинэ түвшинд хүрч чадсан байна.

Эдүгээ цаг дор шүүх эрх мэдлийн болон хуулийн шинэчлэл эрчимтэй, тасралтгүй үргэлжлэн хийгдэж байна. Шинэчлэлийн замд бас л хүндрэл учруулсан олон хүчин зүйлс байхаас гадна хувийн, бүлгийн явцуу эрх ашиг, өөрт таалагдаагүй гэх сэдлээр шинэчлэлийг ухраах, эрчийг сааруулан саад хийх, улс төржүүлэх зэрэг сөрөг хандлага гарсаар л байна.

Бид ухрах бус урагшаа давшин тэмүүлэх ёстой. Бидэнд хийсэн ажил их бий, цаашид хийх ажил ч багагүй байна. Энд та бидний идэвхтэй оролцоо, оновчтой-шинэ санал, санаачилга чухал билээ.

“Гартай бүхэн гавшгайлагтун,
Хөлтэй бүхэн хөдлөгтүн,
Гэр ордын үйл хэргийг бүтээхэд
Хүмүүн бүр хүчин зүтгэсүгэй,
Аугаа ууч сэтгэлийг барьж
Аху төрд тустайг үйлдэгтүн,
Авах, гээхийн ухаан зарж
Алдсан, оносноо дэнслэн ухагтун” гэж Чингис хаан айлджээ.



“Шүүх бол бидний гэр орд” юм. “Улсын шүүх & Улсын шүүгч” гэдэг бол орчин цагийн эрх зүйт ёс, ардчиллын үнэт зүйлсийн эрх зүйн товч утга агуулгаар :

Төрийн эрх мэдлийн тэнцвэр хяналтын тулгуур багана
Төрийн хууль, хүний эрхэд харш үйлтэнд гэм зэм тогтоох дээд эрх
Төр, иргэн хэн боловч тэгш үйлчлэх шударга үнэний хүрээлэн
Төрийн зүрх энх цохилж, ой санамж нь саруул сэтгэхийн амин үндэс
Эрх зүйт төр оршихуйн нотолгоо
Эрдэнэт хүмүүний эрхийн баталгаа
Эзэн Чингисийн зарлигтай бүрэн эрхэт элч
Эрхэм төрийн алтан жолоог барилцагч
Хууль цаазыг чанд сахиулах дээд хяналт
Үнэн худлын шалгуур дэнс
Үнэт зүйлс шударга ёсны эрэлчин
Хамаг Монголын өмнөөс онцгой эрх эзэгнэгч Фемида.
Ийнхүү, Монгол Улсад шүүх байгуулагдсаны түүхэн ой”-г угтан “Бүтээлч санаачилга” гарган,
хамтран хэрэгжүүлэхийг уриалж байна.

“Монголын шүүхээс Монголын төр, хууль цаазын түүх уншигддаг, бичигддэг” билээ.

Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж
заалдах шатны шүүхийн хамт олон,
шүүгч Г.ГАНБААТАР